

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын 2 дугаар багийн 13, 14-р хэсгийн цэвэр, бохир усны шугамын ажил:

А. Ажил гүйцэтгэх хугацааны график/ хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Гадна цэвэр ус, бохир усны шугам сүлжээний угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

*В. Үнийн саналд зураг төсвийн үнийг **3 940 000 /Гурван сая есөн зуун дөчин мянга/ төгрөг, инженер геодезийн дэвсгэр зургийн үнэ **2 400 000 /Хоёр сая дөрвөн зуун мянга/ төгрөг нийт **6 340 000 /Зургаан сая гурван зуун дөчин мянга/ захиалагчийн хяналтын зардлыг Барилга угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-иар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгаж ирүүлнэ.*******

Г. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах

1. Гадна цэвэр усны шугамын угсралтын ажил

Гадна цэвэр ус, бохир усны шугамын ажлыг гүйцэтгэхдээ Ус хангамж, Гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-02-16, Ус хангамж, ариутгах татуургын гадна сүлжээ барилга байгууламж БНБД 40-04-16-г тус тус баримтална.

Усан хангамжийн шугамыг УТБ8-ын дэргэдэх ЦУХ-1 аас ф90мм шугамаар огтолгоо авч угсралт хийнэ. Нийт цэвэр усны 18 худаг угсрагдана.

Шугам хоолой:

Цэвэр усны шугам хоолойг MNS4427:2007 стандартанд нийцсэн PE маркийн ф90мм-ийн 1,0 МПа даралттай хуванцар хоолойгоор хийнэ. Зам доор болон бохир усны шугамтай огтлолцсон хэсэгт гэр хоолой хийнэ. Гэр хоолойг ГОСТ 10704-91 стандартын ф200мм-ээс багагүй диаметртэй ган хоолойгоор хийнэ.

Цэвэр усны худаг:

Цэвэр усны шугам сүлжээнд дугуй огтлолтой төмөр бетон нэг маягийн выпуск 901 холболтын буюу үзлэгийн худгууд тавина. Холболтын болон үзлэгийн худгийг зурагт заасан зайнуудад байрлуулна. Холболтын болон үзлэгийн худгуудын дээд түвшин замын түвшинд байрлана.

Худгийн таг:

Таг авто замтай нэг түвшинд байрлана. Үзлэгийн худгуудад хөлдөлтөөс хамгаалах дулаалгатай модон таг хийнэ. Худагт орж гарах шат хийнэ. Шугам хоолойнуудын угсралтын ажлыг гүйцэтгэхэд дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

- Техник аюулгүйн болон газар шорооны ажил гүйцэтгэх БНбд 3.02.01-90-ыг чанд мөрдөх,
- Газар шорооны ажлыг эхлэхийн өмнө холбогдох газруудаас зөвшөөрөл авч, цахилгааны болон бусад шугам сүлжээтэй огтлолцож байгаа хэсгийг тэмдэглүүлж, гараар ухах ба шугам сүлжээнд хамгаалалт хийж, угсралтыг гүйцэтгэн буцааж булагдаа хөрсний нягтруулалтыг БНбд 3.05.04-90-ийн дагуу хийх.
- Шугам хоолойг булахаас өмнө холбогдох төлөөллийг байлцуулж, битүүмжлэлийг нь шалган далд ажлын акт хөтлөх,

2. Гадна бохир усны шугамын угсралтын ажил

Гадна бохир усны шугамын ажлыг гүйцэтгэхдээ Ариутгах татуурга, Гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-01-14, Ус хангамж, ариутгах татуургын гадна сүлжээ барилга байгууламж БНБД 40-04-16-г тус тус баримтална.

Бохир усыг өөрийнх урсгалаар зайлуулах ба нэг хэсгийг одоо байгаа бохир усны БУХ-7 худагт холбоно. Нөгөө хэсгийг БУХ-1 худагт холбоно. Нийт 20ш худаг шинээр барина. Бохир усны шугамын угсралтыг трассын дагуу нивеллирдэж өндөржилтийн тооцоог гарган ашиглагч байгууллагатай зөвшилцсөний дараа хийж гүйцэтгэнэ.

Бохир усны худгийн бетон хийцүүдийг стандартын дагуу худагт төмөр шат, дулаалгатай модон таг заавал хийж өгнө.

Угсралтын ажлыг гүйцэтгэхдээ шугамын гүн налууг маш нарийн тооцож зориулалтын геодезийн багаж ашиглан гүйцэтгэх хэрэгтэй.

Улаан шугам тавьж бохирын холболт орж ирэх барилгуудын гаргалгааны гүнийг талбайн өндөржилттэй уялдуулан худгийн өндөр, шугамын гүнийг тохируулах боломжтой.

Трассын дагуу цахилгаан, холбоо, дулаан, цэвэр усны шугамууд таарч болзошгүй тул бүх шугам сүлжээний төлөөлөлд мэдэгдэж байлцуулах, угсралтын ажил эхлэхийн өмнө дахин зургийн дагуу тодруулга хийлгэхийг онцгойлон анхаарах нь зүйтэй. Бохир усны шугам холбооны шугамын трассын дагуу хийгдэх тул тухайн газраас тодруулга авч ажлыг эхлүүлэх.

Авто замын доогуур хөндлөн гарах шугамын хэсгүүдэд ган яндангаар бүрхэвч хийж өгөх, буцааж замыг сэргээх, мөн дайрч өнгөрөх явган зам бетон талбай, төмөр хайс, бетон хашаа, сүүдрэвч зэргийн буцааж сэргээж өгнө.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Барилга байгууламжийн ажлыг батлагдсан зураг төсөл, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилга байгууламжийн ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
6. Барилга байгууламжийн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
7. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хий, бүтээц, цэвэр бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.
8. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
9. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх

бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.

10. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
11. Тендерийн төсвийг тэргүүлэх болон мэргэшсэн зэрэгтэй /эрхийн хугацаа дуусаагүй, тухайн ажилбарын хүрээнд хамаарах/ төсөвчнөөр гүйцэтгүүлнэ.
12. Үнийн саналд Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, зохиогчийн хяналт, зураг төсвийн үнэ, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД “Ү” 81-95-12-г мөрдлөг болгоно.
13. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.